



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.1, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2013 оны 446 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг эрүүл мэндийн байгууллага бүр мөрдлөг болгон ажиллахыг бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД

ГШИЙЛЭГДАМБА



Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 08 өдрийн  
189 дугаар тушаалын хавсралт

## ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРАНД МӨРДӨХ НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйлс:

1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагад тусlamж, үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын байранд мөрдөх нийтлэг хэм хэмжээ, үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг тодорхойлоход оршино.
2. Энэхүү үйл ажиллагаа нь үйлчүүлэгчийн тав тухтай үйлчилгээ авах орчныг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хамгаалах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
3. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагад итгэл, үнэмшлийг төрүүлэх, үйлчлүүлэгчтэй албан харилцааг үүсгэх нөхцөл нь эрүүл мэндийн ажилтнуудын биеэ авч явах, хувцаслах, гадаад өнгө төрх, харилцааны илэрхийлэл болно.
4. Эрүүл мэндийн ажилтан, тодорхой хэм, хэмжээний хүрээнд биеэ авч явах соёлыг хэвшигүүлсэн байх нь эрүүл мэндийн салбарын онцлог болно.
5. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү нийтлэг журам болон тусlamж, үйлчилгээнийхээ өвөрмөц онцлогт нийцүүлэн, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны дүрэмт хувцасны төрөл, загвар, хэрэглээ, тавигдах шаардлагыг тусгасан журам боловсруулж, батлан хэрэгжүүлж ажиллана.
6. Энэхүү журам нь ёс зүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, халдварт хамгааллын зарчмуудыг тусгасан хууль, эрх зүйн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангахад чиглэгдэх бөгөөд эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан байна.
7. Журам нь зөвхөн ажлын байранд мөрдөгдөнө.

### Хоёр. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд баримтлах нийтлэг зарчим.

1. Үйлчлүүлэгчийг хүндэтгэх,
2. Үйлчлүүлэгчийн итгэлийг хүлээх, нууцыг хадгалах,
3. Үнэнч байх,
4. Тэгш байдлыг хангах зарчим,
5. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлтэд нийцсэн, батлагдсан стандарт, хэм хэмжээнд нийцүүлэн хүргэх,
6. Мэргэжлийн тодорхой зарчим, хэм хэмжээг баримтлах,
7. Ашиг сонирхлын зэрчилгүй байх,
8. Хамт олон, ижил мэргэжилтнээ хүндэтгэх,
9. Хувийн болон мэргэжлийн ёс зүйг баримтлах,
10. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээний журамд заасан хэм, хэмжээ,
11. Хууль, эрхийг хүндэтгэх түүний хүрээнд үйл ажиллагааг эрхлэх,

### Гурав. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг хэм, хэмжээ.

**3.1 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг харилцааны хэм хэмжээ.**

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь үйлчлүүлэгчтэй мэндлэх үедээ элэгсэг дотно, эелдэг зөөлнөөр, туслах чин эрмэлзлэлтэйгээр үйлчлүүлэгчийн нүд рүү цэх харж, хүндэтгэсэн өнгөөр мэндчилнэ.
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь үйлчлүүлэгчтэй эхэлж мэндлэх ба “*ta, ta nar, ta бүхэн*” гэсэн үг хэллэг хэрэглэнэ.
3. Асуудлыг тайлбарлахдаа гарын хөдөлгөөн зөөлөн, биеийн байрлал, нүүр царай, харц нь дэмжсэн өнгө аястай байхаар намдуу, зөөлөн дуугаар тайлбарлаж, чиглүүлнэ.
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа сандарч тэвдсэн байдал үзүүлэх, хөшүүн хойрго байх, чанга дуугаар ярих, хашгирах, инээхийг цээрлэж, тайван, зөөлөн, урам зоригтой, итгэлтэй байна.
5. Үйлчлүүлэгчийн нас, хүйс, зан заншил, шашин шүтлэг, албан тушаал, эрх мэдэл, нийгмийн гарал, баян, ядуу, хөгжлийн бэрхшээлтэй болон бэлгийн чиг хандлагаас үл хамааран талархсан сэтгэлээр хүлээн авч, зочин мэт үйлчилнэ.
6. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь өөдрөг сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй байж, хамт олон, үйлчлүүлэгчдэд итгэл үнэмшил, баяр баясгаланг өгөхийн төлөө тасралтгүй суралцаж, чармайн ажиллана.


**3.2 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд нийтлэг мөрдөх хувцаслалтын хэм хэмжээ.**

Код	Төрөл	Хэн хэзээ хэрэглэх	Зөвшөөрөгдсөн хэм хэмжээ	Хориглох хэм хэмжээ
<b>I</b>	<b>Хувцаслалтын хэм, хэмжээ</b>			
1	Энгэрийн таних тэмдэг	Ажлын байранд ажил хариуцан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцагчийн нүдэнд шууд тусахаар зүүн талын энгэрт зүүх ба овог нэр, албан тушаал тодорхой бичигдсэн,</li> <li>- Үйлчлүүлэгчээс 5 алхамын зайнаас тод харагдахуйц бичигдсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил үүрэг гүйцэтгэж байх явцад энгэрийн таних тэмдэг эргэхээр хөдөлгөөнтэй байх буюу урт оосортой, хүзүүнээс зүүсэн,</li> <li>- Ажлын байранд энгэрийн таних тэмдэг зүүгээгүй байх</li> <li>- Энгэрийн таних тэмдэгт буй мэдээлэл уншигдах боломжгүй байх</li> </ul>
2	Эмнэлгийн малгай	Байгууллагын журамд заавал малгай өмсөхөөр заасан газар, хэсгүүдэд	<ul style="list-style-type: none"> <li>- Үсийг бүрэн далдалсан,</li> <li>- Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийг халдвараас сэргийлэх нөхцлийг хангасан,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээний хэсэгт чихэвч,</li> <li>- бусад тоноглол бүхий зориулалтын бус малгай өмсөх</li> </ul>

3	Ажлын хувцасны ханцуй	Байгууллагын журамд заасан ажил мэргэжлийн онцлог хэсэгт тохирсон	Мөр хэсгийг заавал далдалсан, урт ба богино ханцуйтай халаад, цамц	- Биеийн мөр, цээж хэсэг ил гарсан, - Биеийн хэсэг гэрэлтэхээр нимгэн материалтай байх
4	Ажлын богино халаад	Байгууллагын журамд заасан ажил мэргэжлийн онцлог хэсэгт тохирсон	Энгэрийн ухлаадас нь зөвхөн эгэм хүрсэн шулуун, энгийн загвартай,  /ажлын онцлогоос шалтгаалан өнгийг ялгавартай байхаар байгууллагын журамд тусгасан, хэм, хэмжээ/	- Биеийн хэлбэр харагдуулахуйц бариу, богино халаад, өмд, - Энгэрийн ухлаадас гүнзгий, задгай энгэртэй, - Тод өнгийн, - Биеийн хэсгүүд гэрэлтэх нимгэн болон торон материалтай, - Богино халаад дээр банзал өмсөх,
5	Ажлын урт халаад	Ажлын онцлогт тохирсон, байгууллагын журамд заасан ажлын байранд	- Бие бариагүй, шулуун, - Ажил хэрэгч загвартай, - Хөдөлгөөн хязгаарлаагүй, - Урт нь өвдөг орчим эсвэл өвдөгнөөс доош 5 см байх, буюу суухад өвдөг, хөлийг далдах урттай - Энгэрийн ухлаадас нь зөвхөн эгэм хүрсэн, - Ажлын байрны онцлогоос шалтгаалсан ханцууны уяа, бүч, хэрэглэхийг зөвшөөрсөн хэсэгт зөвшөөрнө.	- Биеийн хэлбэр харагдуулахуйц бариу, - Заасан хэмжээнээс урт, богино, - Тод өнгийн, - Биеийн хэсгүүд гэрэлтэх нимгэн болон торон материалтай
6	Ажлын өмд	Ажлын онцлогт тохирсон, байгууллагын журамд заасан ажлын байранд	- Бие бариагүй, хөдөлгөөн хязгаарлаагүй, - Урт нь шагай хүрсэн - Энгийн загвартай	- хэт бариу - Хэт тод өнгийн, - Биеийн хэсгүүд гэрэлтэх нимгэн болон торон материалтай, - Хэт богино, хэт загварлаг

7	Гутал	Тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	- Эмнэлгийн зориулалтын, зөвлөн ултай, - Хальтиридаггүй, - Хөлийн хуруунууд ил гараагүй, - Эмэгтэй гутлын өсгий 5,5 см-аас өндөргүй, эсвэл үргэлж зөвлөн ултай, - Журамд заасан нэг өнгийн	- Хэт тод өнгийн, - Хэт өндөр өсгийтэй, - Хөлийн хэсгүүд хэт ил гарсан, сандаал, - Хэт загварлаг, - Явахад дуу чимээ их гаргадаг, - Бохирлогдсон буюу, бохир байх, - Биеийн тамирын зориулалтын гутал өмсөх - Хөлийн хэмжээнд тохироогүй, томдсон, жижигдсэн гутал
8	Оймс	Тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	- Богино оймс нь хөлийн шагайнаас дээш 4 см -аас доошгүй, - Тусламж, үйлчилгээ үзүүлэхэд болох саад уяа, унжлагагүй	- Хэт тод, - Олон өнгийн, анхаарал сарниулах өнгөтэй, - Хөвөрч, урагдсан, - Бохир
9	Ээмэг, зүүлт	Тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	- Заасан ажлын байранд аюулгүй байдлыг хангасан өнгийн жижигт, ээмэг зүүлт,	- Том, хүний анхаарал татахуйц урт ээмэг, зүүлт, гинж, бугуйч - Олон тооны ээмэг, зүүлт зүүх
10	Бөгж	Тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	- Зүүхгүй - Захиргааны ажилтнаас бусад	- Иргэн, үйлчлүүлэгчид мэс болон бусад гардан ажилбар, тариа тарилга, угаалга цэвэрлэгээ хийж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд бөгж зүүх
11	Бугуйн цаг	Тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	- Энгэрийн цаг хэрэглэж болно	- Бугуйн цаг зөвшөөрөхгүй

II	Харилцааны хэм, хэмжээ			
12	Биеийн хэлний ерөнхий хэм, хэмжээ	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчтэй харилцах үедээ бие, нүүрний төрхийг эерэг байдлаар төвлөрүүлэн харилцах,</li> <li>- Элэгсэг, үнэн сэтгэлээс нам дуугаар мэндчилэх,</li> <li>- Үйлчлүүлэгчээс урьдан эхэлж мэндлэх,</li> <li>- Үйлчлүүлэгчтэй зөрж өнгөрөхдөө мэндлэх, анхаарч байгаагаа илэрхийлэх,</li> <li>- Асуудлыг тайлбарлахдаа намдуу дуугаар зөвлөсөн, дэмжсэн өнгөөр харилцана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үл тоосон байдал гаргах,</li> <li>- Гараа халаасандаа хийсэн байх,</li> <li>- Ташаа тулах,</li> <li>- Нуруугаа үүрсэн байх,</li> <li>- Гар хуруугаар дохих, зангах,</li> <li>- Харц дээгүүр байх,</li> <li>- Төвөгшөөсөн байдал, ундууцсан байдал гаргах,</li> <li>- Сандарч тэвдсэнээ ил гаргах,</li> <li>- Хөшүүн хойрго байх,</li> <li>- Чанга хашгирч ярих, инээх</li> <li>- Бөхь зажлах</li> <li>- Амандаа идэх зүйл хийсэн байдалтай ажил, үүрэг гүйцэтгэх,</li> <li>- Үйлчлүүлэгчийн дэргэд хоол идэх,</li> <li>- Үйлчлүүлэгчийнхээ талаар олон нийтийн газарт хэлэлцэж, чангаар ярилцах</li> <li>- Олон нийтийн газарт хамт ажиллагсадыгаа шүүмжлэх, чангаар ярилцах,</li> <li>- Хэт мэдэмхийрэх, хүний өмнөөс тайлбар хийх</li> </ul>
13	Харилцааны хэлний ерөнхий хэм, хэмжээ	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчийн нэрийг хэлж мэндчилнэ</li> <li>- Өөрийгөө танилцуулна</li> <li>- Үйлчлүүлэгчид ойрхон, нүдний харц нэг түвшинд,</li> <li>- Үйлчлүүлэгчийн байрлал түүнд тавтай байгаа эсэхийг тодруулах,</li> <li>- Нээлттэй энгийн, ойлгогдох асуулт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн ойлгогдохгүй нэр томьёо хэрэглэн харилцах</li> <li>- Бүдүүлэг үг хэллэг хэрэглэх</li> </ul>

			<p>тавьж, ярилцах,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчийг яаруулахгүйгээр санаа бодлоо илэрхийлэх боломж олгоно</li> </ul>	
<b>III</b>	<b>Биеэ авч явах соёл /Гадаад харагдах байдлын/-ын хэм, хэмжээ</b>			
14	Ажлын хувцасны хэрэглээ	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд	<ul style="list-style-type: none"> <li>- Дүрэмт хувцасны цахилгаан ба товч бүрэн товчлогдсон,</li> <li>- Хир толбогуй,</li> <li>- Дүрэмд заагдсан өнгийн,</li> <li>- Зөвхөн зөвшөөрөгдсөн хэсэгт өмсөх зориулалтаар нь хэрэглэнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Энгэр задгай,</li> <li>- Товч бүрэн бус,</li> <li>- Хиртэй, толботой,</li> <li>- Зориулалтын бус газар өмсөж хэрэглэх /эмнэлгийн гадаа гудамжинд, бусад албан байгууллагад эмнэлгийн дүрэмт хувцастай орох, хэрэглэх/</li> <li>- Эмнэлгийн гадаа ойр, орчим, худалдаа, олон нийтийн газарт дүрэмт хувцастай үзэгдэх,</li> <li>- Мэс заслын ариутгасан хэсэг, ариун хэсэгт өмсөх хувцас, хэрэгслийг зориулалтын бус хэсэгт хэрэглэх, зорчих,</li> </ul>
15	Хувийн гар утас хэрэглэх	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Тусlamж, үйлчилгээг үзүүлж байх үедээ, гар утас хэрэглэхийг хориглоно</li> <li>- Тусlamж, үйлчилгээ үзүүлэхээс бусад нөхцөлд гар утсыг ажлын байранд хэрэглэх бол нам дуугаар хариулах буюу, гар утасны дуудлагын хонхыг зөвхөн чичиргээ тохиргоонд тааруулсан байна.</li> <li>- Хувийн гар утсаараа, үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээ үзүүлж байх үедээ гар утас хэрэглэх</li> <li>- Үйлчлүүлэгчийн дэргэд утсаар чанга ярих, бүдүүлэг уг хэллэг хэрэглэх,</li> <li>- Дуу сонсох, бичлэг үзэх</li> </ul>

			бичлэг хийх, зураг авахыг хориглоно	
16	Албаны утас	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Утсыг аваадаа эхэлж мэндэлж, тухайн ажлын байрны нэр, өөрийн нэрийг хэлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын утсаар олон цагаар хувийн чанартай зүйлсийг ярих,</li> <li>- Хэтчанга ярих,</li> <li>- Бүдүүлэг үг хэллэг хэрэглэх,</li> <li>- Маргалдах,</li> </ul>
17	Биеийн шивээс	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэв биед шивээстэй бол ажлын дүрэмт хувцас өмсөхөд бүрэн далдлагдсан байх,</li> <li>- Нүүр, гарын ил хэсэгт зөвшөөрөхгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөл бүрийн зураг бүхий шивээс нь ил байх</li> </ul>
18	Үнэртэн	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн ариун цэврийг сахисан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэт хурц үнэртэй үс,</li> <li>- Өвчтэй болон үнэртэнд харшилтай үйлчлүүлэгчид эвгүй сэтгэгдэл төрүүлэх,</li> <li>- Эмийн үнэр дарангуйлах</li> </ul>
19	Толгойн үс	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Цэвэр, самнасан,</li> <li>- Өвчтөнд тусlamж үйлчилгээ үзүүлэхэд саад болохооргүй,</li> <li>- Урт бол шууж боосон,</li> <li>- Ажил хэрэгч засалттай,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үсийг тод ялгарах өнгөөр будсан</li> <li>- Хэт урт үсийг задгай тавьсан,</li> <li>- Этгээд засалттай,</li> <li>- Элдэв чимэгтэй, тод өнгийн зүүлт, хавчаар зүүх,</li> <li>- Эрүүл мэндийн шаардлагаас бусад тохиолдолд хиймэл үс зүүх</li> </ul>
20	Нүүрний үс	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Хамар ба чих доторхи үсийг зохих түвшинд арчилсан,</li> <li>- Сахалыг хэвийн хэмжээнд засуулсан</li> <li>- Дээд уруул даваагүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамар, чихний үс, сахалыг хэт ургуулсан,</li> <li>- Хэт урт сахал,</li> </ul>
21	Нүүр будалт	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	<ul style="list-style-type: none"> <li>- Хэвийн хэмжээнд, бие арчлах энгийн түвшинд байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тод өнгөөр нүд, хөмсөгийг будах,</li> <li>- Хэт будах</li> <li>- Хиймэл сормуус</li> </ul>

22	Харааны шил	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	- Энгийн хэлбэр, загвар, өнгөтэй байна	- Хэт загварлаг, - Гоёлын зориулалтын шилийг ажлын байранд хэрэглэх
23	Гарын хумс	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байранд	- Хиргүй, цэвэрхэн, - Богино засалттай, - Будагүй,	- Хиймэл хумс, - Урт ургуулсан хумс, - Будагтай хумс, - Тод будсан, - Чимэглэл наасан
<b>IV Ажлын хамгаалах хувцас хэрэгсэл</b>				
24	Физикийн хүчин зүйлстэй харилцах	Цахилгаан соронзон орон, ионжуулагч цацраг (рентген, цацраг идэвхит эх үүсвэр), цахилгаан, температуртай нөхцөлд ажиллагсад	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Амьсгал хамгаалах хэрэгсэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>- нүүрийг хагас халхалсан баг, хий, уурыг шүүх идэвхжүүлсэн нүүрс зэрэг шингээгчтэй баг,</li> <li>- нүүрийг бүрэн халхалсан баг</li> </ul> </li> <li>- агаар нөөцлөгчтэй баг,</li> <li>- шүүлтүүртэй баг г.м</li> </ul> <p>- <b>Бээлий:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Механик гэмтлээс хамгаалах,</li> <li>- уусгагчдаас хамгаалах,</li> <li>- биологийн бохирдуулагчаас хамгаалах</li> </ul>	Зориулалтын бус хувцас, хэрэгсэл
25	Химийн хүчин зүйлстэй харилцах	Ариутгал, халдвартгүйтгэл ийн бодис, уусмал, цэвэрлэгээний бодис уусмал, эм, лабораторид хэрэглэж байгаа химийн бодистой ажиллагсад г.м	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Хамгаалах хувцас:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Нэг удаа эсвэл олон дахин ашиглах хамгаалах хувцас, хэрэгсэл,</li> </ul> </li> <li>- Энгийн, Гоц халдвартын үеийн хувцас, хэрэгсэл</li> </ul> <p>- <b>Гутал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Битүү,</li> <li>- Хурууны төмөр хамгаалалтай</li> </ul>	Зориулалтын бус хувцас, хэрэгсэл
26	Биологийн хүчин зүйлстэй харилцах	Үйлчлүүлэгчийн биеийн шингэн, цус болон халдвар авах эрсдэлтэй орчин, нөхцөлд ажиллагсад	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Хамгаалах хувцас:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Нэг удаа эсвэл олон дахин ашиглах хамгаалах хувцас, хэрэгсэл,</li> </ul> </li> </ul>	Зориулалтын бус хувцас, хэрэгсэл
27	Механик болон эргономикийн хүчин зүйлстэй хайлцах	Ажлын ачаалал, ажлын байрлал, үйлчлүүлэгчийг зөөх, өргөх ажил, хурц ир, үзүүртэй зүйлсээр биеэ гэмтээх эрсдэл, аюултай нөхцөлд	<ul style="list-style-type: none"> <li>- Энгийн, Гоц халдвартын үеийн хувцас, хэрэгсэл</li> <li>- <b>Гутал:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Битүү,</li> <li>- Хурууны төмөр хамгаалалтай</li> </ul> </li> </ul>	Зориулалтын бус хувцас, хэрэгсэл

		ажиллагсад	<ul style="list-style-type: none"> <li>- Ус, чийгний хамгаалалттай,</li> <li>- <b>Нүд хамгаалах шил:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Энгийн</li> <li>- Тусгай зориулалтын</li> </ul> </li> <li>- <b>Сонсгол хамгаалах хэрэгсэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Өвөрмөц орчин нөхцөлд ажиллах зориулалтын</li> </ul> </li> </ul>	
--	--	------------	--	--

#### Дөрөв. Хяналт, үнэлгээ

1. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд журмын хэрэгжилтийг хангаж ажиллах орчин, нөхцлийг бүрдүүлж ажиллана.
2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмын заалтыг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг ёс зүйн хэм, хэмжээний алдаанд тооцож, зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг авна.
3. Эрүүл мэндийн байгууллагын чанарын алба, сувилгааны алба, асуудал хариуцсан мэргэжилтэн нь журмын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавьж ажиллах ба чанарын тасалбар ажиллуулахдаа эдгээр хэм, хэмжээг шалгур болгон хэрэглэж болно.
4. Эрүүл мэндийн байгууллага нь дүрэмдээ хувцас хэрэгслийн ариун байдлыг хадгалах, түүний хэрэглээ, цэвэрлэх болон устгах, солих ээлжийн тоо, хугацаа, бусад өвөрмөц асуудлыг энэхүү журам болон бусад холбогдох хууль эрхийн хүрээнд нийцүүлэн тусгаж, хэрэгжүүлнэ.
5. Эрүүл мэндийн байгууллага нь журмын хэрэгжилтэд явцын хяналт тавьж, бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт, үнэлгээг хийж ажиллана.